

ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮ, ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН, ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ САН, ХҮҮХЭД, ГЭР БҮЛ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН АСУУДАЛ
ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.БАТЦЭЦЭГИЙН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д /д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл- тийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Хүүхэд, гэр бүл, нийгмийн даатгалын салбарын хөгжлийн богино, дунд хугацааны стратеги, үндсэн чиглэлийг үндэслэн Нийгмийн даатгалын сан, хүүхдийн төлөө сан болон хүүхэд, гэр бүл, нийгмийн даатгалын салбарын байгууллагуудын үйл ажиллагааны богино, дунд хугацааны төсвийн төлөвлөлтийг боловсруулах”							
1.	Арга хэмжээ № 1.1 Нийгмийн даатгал, хүүхэд, гэр бүлийн салбарын богино, дунд хугацааны стратеги, үндсэн чиглэлийг үндэслэн Хүүхдийн төлөө сан, Нийгмийн даатгалын сан болон тус салбарын үйл ажиллагааны жилийн болон дунд хугацааны төсвийн саналыг боловсруулах;	Шаардагдах төсвийг тусгаж боловсруулсан байна. /тийм-1, үгүй-0/	-	1	Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газраас ирүүлсэн Хүүхдийн төлөө сан, Нийгмийн даатгалын сангийн болон харьяа газар, хэлтсүүдийн үйл ажиллагааны зардлын 2025 оны төсвийн төслийн саналыг Нийгмийн даатгал, хүүхэд, гэр бүлийн салбарын богино, дунд хугацааны стратеги, үндсэн чиглэлийг үндэслэн хянаж, яамны холбогдох газар, хэлтсийн саналыг тусган боловсрууллаа.	2024.07.25	100
2.	Арга хэмжээ № 1.2. ТЕЗ-ийн хэрэгжүүлэх төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг боловсруулахад холбогдох агентлаг, газар, хэлтсийн саналыг хүлээн авч нэгтгэн тусгуулах;	Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тоон болон чанарын шалгуур үзүүлэлтэд холбогдох салбарын санал туссан байна. /тийм-1, үгүй-0/	-	1	Нийгмийн даатгал, хүүхэд, гэр бүлийн салбарын 2025 онд хэрэгжүүлэх төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийн саналыг холбогдох агентлаг, газар, хэлтсээс хүлээн авч нэгтгэн боловсрууллаа.	2024.07.25	100

3.	Арга хэмжээ № 1.3 Нийгмийн даатгал сан, Хүүхдийн төлөө сан болон нийгмийн даатгал, хүүхэд, гэр бүлийн байгууллагуудын үйл ажиллагааны төсвийг хуулийн хугацаанд тайлбар танилцуулгын хамт холбогдох байгууллагад хүргүүлэх;	Хуулийн хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. /тийм-1, үгүй-0/	-	1	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөлөл, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн саналыг Монгол Улсын төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн яамнаас ирүүлсэн чиглэл удирдамжийн дагуу боловсруулан танилцуулга, холбогдох тооцооллын хамт 2024 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 01/28 дугаар албан бичгээр Улсын Их Хурал болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний аудитын газарт хүргүүлж ажилласан.	2024.07.25	100
4.	Арга хэмжээ № 1.4 Төсвийн төслийг Засгийн газар, УИХ-аар хэлэлцэх явцад Нийгмийн даатгалын сан, Хүүхдийн төлөө сан болон нийгмийн даатгал, хүүхэд, гэр бүлийн байгууллагуудын үйл ажиллагааны төсвийн талаар тайлбар, үндэслэлийг гарган удирдлагыг мэдээллээр хангах;	Төсвийн төслийг хэлэлцэх явцад тайлбар танилцуулга, тооцооллыг холбогдох газар, хэлтсийн дарга бусад албан тушаалтанд гаргаж өгч мэдээллээр хангасан байна. /тийм-1, үгүй-0/	-	1	Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсөв хэлэлцэгдэх явцад салбарын сайд, удирдлагуудыг Нийгмийн даатгалын сан, Хүүхдийн төлөө сан болон нийгмийн даатгал, хүүхэд, гэр бүлийн байгууллагуудын үйл ажиллагааны төсвийн талаар болон хүүхэд хамгааллын зардал, 2025 онд шинээр нэмэгдэж буй хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудын цалингийн тооцоо, хүүхэд, харах үйлчилгээний зардал, ХХДХ нэмэгдсэнтэй холбоотой 2025 оны төсөвт гарах нөлөөллийн талаарх тайлбар, үндэслэл, танилцуулга, мэдээллээр ханган ажиллав. Мөн хариуцсан салбарын төсвийн зарлагын хүлээгдэж буй гүйцэтгэлийг зардлын зүйл, төсөл хөтөлбөр бүрээр гарган тайлбар, танилцуулгыг Сангийн яам, УИХ-ын Байнгын хороодод хүргүүлэн ажиллаа.	2024.12.10	100
Зорилт 2. “Нийгмийн даатгалын сан, хүүхдийн төлөө сан, хүүхэд, гэр бүл, нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны төсвийн төлөвлөлтөд дүн шинжилгээ хийж, төсвийн хөрөнгийг зөв зохистой, үр ашигтай удирдах, зайлшгүй шаардлагатай тохиолдолд зохицуулалт хийх, төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулах, батлагдсан төсвийг зардлын зүйлээр хуваарилж санхүүжүүлэх”							
1.	Арга хэмжээ № 2.1 Нийгмийн даатгалын сан, Хүүхдийн төлөө сан болон нийгмийн даатгал, хүүхэд, гэр бүлийн төсөвт байгууллагуудын төсвийг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлж салбарын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах;	Батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлсэн байна. /тийм-1, үгүй-0/	-	1	Нийгмийн даатгалын сан, Хүүхдийн төлөө сан болон нийгмийн даатгал, хүүхэд, гэр бүлийн төсөвт байгууллагуудын төсвийг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлж салбарын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр ханган ажиллаа.	2024.12.10	100

2.	Арга хэмжээ № 2.2 Нийгмийн даатгалын сан, Хүүхдийн төлөө сан болон нийгмийн даатгал, хүүхэд, гэр бүлийн байгууллагуудын үйл ажиллагааны төсвийн төлөвлөлтөд дүн шинжилгээ хийж, хуваарилалтад хяналт тавих, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллах;	Удирдлага мэдээллээр хангагдсан байна. /тийм-1, үгүй-0/	-	1	Нийгмийн даатгалын сан, Хүүхдийн төлөө сан болон нийгмийн даатгал, хүүхэд, гэр бүлийн байгууллагуудын үйл ажиллагааны төсвийн төлөвлөлтөд дүн шинжилгээ хийж, хуваарилалтад хяналт тавин, удирдлагыг мэдээллээр ханган ажиллаа.	2024.12.10	100
3.	Арга хэмжээ № 2.3 Зайлшгүй шаардлагатай тохиолдолд Нийгмийн даатгалын сан, Хүүхдийн төлөө сан болон нийгмийн даатгал, хүүхэд, гэр бүлийн байгууллагуудын үйл ажиллагааны төсөвт зохицуулалт хийх, төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулах;	Ирүүлсэн санал зохих түвшинд шийдвэрлэгдсэн байна. /тийм-1, үгүй-0/	-	1	Харьяа агентлаг, төсөвт байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг хянаж, нэгтгэн төсвийн сар, улирлын хуваарьт зохицуулалт хийх саналыг бэлтгэж Сангийн яаманд хүргүүлэн зохих түвшинд шийдвэрлүүлж салбарын үйл ажиллагааг хэвийн явуулах, шинээр өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч ажиллалаа. /ГБХНХСайдын 2024.10.31 01/1061, ГБХНХСайдын 2024.12.04 01/1492 албан бичгүүд/	2024.12.10	100

Зорилт 3. “Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, журмын биелэлтийг хангаж ажиллах”

1.	Арга хэмжээ 3.1. Аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах гэрээний хавсралтад тусгагдах нийгмийн даатгал, хүүхэд, гэр бүлийн салбарын төсвийн саналыг харьяа агентлаг, яамны холбогдох газруудаас авч нэгтгэх;	Батлагдсан төсвийн хүрээнд холбогдох салбарын санал хавсралтад туссан байна. /тийм-1, үгүй-0/	-	1	Аймаг, нийслэлийн засаг дарга нартай байгуулах гэрээний хавсралтад тусгах нийгмийн даатгал, хүүхэд, гэр бүлийн салбарын төсвийн саналыг төсвийн тухай хуулийн хүрээнд боловсруулан, гэрээний хавсралтанд тусгахаар бэлтгэж байна.	2024.12.31	95
2.	Арга хэмжээ 3.2. Аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах гэрээнд тусгуулах шаардлагатай нийгмийн даатгал, хүүхэд, гэр бүлийн салбарын хөтөлбөр, арга хэмжээний хувилбарыг харьяа агентлаг, яамны холбогдох газруудаас авч нэгтгэх;	Холбогдох салбарын санал хавсралтын хувилбарт туссан байна. /тийм-1, үгүй-0/	-	1	ТЕЗ-аас аймаг, нийслэлийн засаг дарга нартай байгуулах гэрээний хавсралтыг төсвийн тухай хуулийн хүрээнд боловсруулан, гэрээний хавсралтанд тусгахаар бэлтгэж байна.	2024.12.31	95

Зорилт 4. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах”

1.	Арга хэмжээ 4.1. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнах;	Албан тушаалын тодорхойлолт болон нэгжийн төлөвлөгөөтэй уялдсан 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө	-	1	Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлагдсан загварын дагуу хуулийн хугацаанд боловсруулан нэгжийн даргаар батлуулж ажиллав.	2024.10.28	100
----	---	--	---	---	--	------------	-----

		батлуулсан байна. /тийм-1, үгүй-0/					
		2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг холбогдох журам зааврын дагуу тайлагнаж, дүгнүүлсэн байна. /тийм-1, үгүй-0/	-	1	Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан ажлын биелэлтийг бүрэн ханган ажиллаж, тайланг батлагдсан загварын дагуу хуулийн хугацаанд тайлагнан ажиллав.	2024.12.10	100
2.	Арга хэмжээ 4.2. Хариуцсан асуудлын чиглэлээр хууль тогтоомж, бодлогын баримт бичигт туссан зорилт, арга хэмжээний биелэлтийг гаргах тайлагнах;	Тайланг тогтоосон хугацаанд бүрэн, оновчтой тайлагнасан байна. /тийм-1, үгүй-0/	-	1	Хариуцсан асуудлын чиглэлээр хууль тогтоомж, бодлогын баримт бичигт туссан зорилт, арга хэмжээний биелэлтийг хуулийн хугацаанд гаргаж тайлагнасан.	2024.09.30 2024.12.10	100
3.	Арга хэмжээ 4.3. Хариуцсан асуудлын чиглэлээр хуулийн төсөл, УИХ, ЗГ-ын тогтоолын төсөлд санал өгөх, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах, мэргэжил арга зүйгээр хангах;	Бодлогын үндэслэлтэй санал өгсөн байна. /тийм- 1, үгүй-0/	-	1	- Төрийн нарийн бичгийн даргын А/86 дугаар тушаалаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны А, Е байрны их засварын ажил /Улаанбаатар, Чингэлтэй/ - ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажиллалаа. "Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны А, Е байрны их засварын ажил /Улаанбаатар хот, Чингэлтэй/"-ийн гүйцэтгэгчийг шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтыг 2024.10.14-ны өдөр зарлаж, 2024.11.05-ны өдөр нээсэн. Тус тендер шалгаруулалтад санал ирүүлсэн "Хөлөг-Од" ХХК, "Өнөших трейд" ХХК-аас "Хөлөг-Од" ХХК-ний ирүүлсэн тендер хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгарсан тул гэрээ байгуулах эрх олгосон. 2024.11.19-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулан засварын ажлыг гүйцэтгэж байна. - Төрийн нарийн бичгийн даргын А/139 дугаар тушаалаар Жаргалант зуслангийн өргөтгөлийн барилга, 60 ор /Булган, Бугат сум/-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж байна. "Жаргалант зуслангийн өргөтгөлийн барилга, 60 ор /Булган, Бугат сум/"-ийн гүйцэтгэгчийг сонгон	2024.09.30 2024.12.10	100

					шалгаруулах тендерийн баримт бичгийг боловсруулан, нээлттэй тендер шалгаруулалтыг 2024.11.20-ны өдөр зарлаж, тендер хүлээн авч байна. 2024.12.13-ны өдөр тендерийг нээнэ. • Төрийн нарийн бичгийн даргын А/91 дугаар тушаалаар Олон Улсын Хүүхдийн Найрамдал цогцолборт гарсан хоолны хордлоготой холбогдуулан хийсэн хяналт шалгалтын дүн, илэрсэн нөхцөл байдалд дүн шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж холбогдох мэргэжлийн байгууллагуудаас хийсэн хяналт шалгалт, тандалт судалгааны дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн илэрсэн нөхцөл байдалд санхүү, төсвийн хүрээнд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан ажиллалаа. • Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/55 дугаар тушаалаар гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт мөрдөх “Албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөв, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандарт”-ын төсөл боловсруулж, батлуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллалаа. • Ахмадын сангийн одоогийн хүндрэлтэй нөхцөл байдлын талаарх танилцуулгыг бэлтгэн /ихэнхи аж ахуйн нэгж, байгууллага дансгүй, ахмадын санд байгууллагын төсвөөс хөрөнгө шилжүүлэхээр зориулалтын зардлаас шилжүүлсэнгүй гэж Аудит акт тавьдаг/ “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын төсөлд оруулах саналаа нэгтгэн Гэр бүлийн бодлогын газарт хүргүүлсэн.		
4.	Арга хэмжээ 4.4. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, албан бичгийг хуулийн хүрээнд шуурхай шийдвэрлэх, хариу хүргүүлэх;	Өргөдөл, гомдол, санал хүсэлт, албан бичгийг шуурхай шийдвэрлэсэн байна. /тийм-1, үгүй-0/	-	1	Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага болон харьяа байгууллагуудаас ирүүлсэн 1 өргөдөл гомдол, 25 албан хүсэлтийг хуулийн хугацаанд тухай бүр шийдвэрлэж ажилласан.	2024.09.30 2024.12.10	100

5.	Арга хэмжээ 4.5. Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад зохион бүрдүүлж буй баримт бичгийг стандартын дагуу хөтлөн явуулах, архив, албан хэрэг хөтлөлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллах;	Баримт бичгийг стандартын дагуу боловсруулан хөтөлж, архивд хүлээлгэн өгсөн байна. /тийм-1, үгүй-0/	-	1	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу өөрийн хариуцсан байгууллагуудаас ирүүлсэн албан бичиг болон зохион байгуулсан тендерийн холбогдох баримт бичгүүдийг архивын нэгж үүсгэн архивын ажилтанд хүлээлгэн өгөхөөр бэлтгээд байна.	2024.09.30 2024.12.10	100
6.	Арга хэмжээ 4.6. Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;	Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж тайлагнасан байна. /тийм-1, үгүй-0/	-	1	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, журмын хүрээнд хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлж ажилласан.	2024.10.28	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Хариуцсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэргэжлийн болон хууль, эрх зүйн мэдлэг чадвараа дээшлүүлэх;	Холбогдох яам, төсөл хөтөлбөр, мэргэжлийн байгууллагаас зохион байгуулсан мэргэжлийн болон тасралтгүй боловсролын сургалтад хамрагдаж мэдлэг чадвараа нэмэгдүүлсэн байна. /тийм-1, үгүй-0/	-	1	- Үндэсний статистикийн хороо, “Төрийн нэгдсэн мэдээллийн сангийн хөгжүүлэлт, удирдлага – ТА10029” төслийн хүрээнд 2024.10.07-2024.10.10-ны өдрийн хооронд зохион байгуулсан Microsoft Excel программын анхан болон дунд шатны сургалтад хамрагдсан. - Европын холбооны санхүүжилттэй НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төсөл, НҮБ-ын Хүүхдийн Сангийн “Төрийн санхүүгийн хөтөлбөр-II”-ийн дэмжлэгээр 2024.10.17-2024.10.18-ны өдөр зохион байгуулсан “Орон	2024.09.30 2024.12.10	100

					нутагт үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг хэвшүүлэх нь” сургалтад хамрагдсан. • Татварын ерөнхий газраас Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9-д орсон нэмэлт өөрчлөлтийн талаар танилцуулах “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт” уулзалт, хэлэлцүүлэгт оролцсон.		
--	--	--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН, ХҮҮХДИЙН
ТӨЛӨӨ САН, ХҮҮХЭД, ГЭР БҮЛ, НИЙГМИЙН
ДААТГАЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨСВИЙН
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

 Б.Батцэцэг/

2024.12.10